

ҮЛ ХӨДЛӨХ ЭД ХӨРӨНГӨ ЗУУЧЛАЛЫН БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1.Энэ журмаар Санхүүгийн зохицуулах хороо (цаашид “Хороо” гэх)-оос үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын үйл ажиллагаа эрхлэхэд тавигдах нөхцөл, шаардлагыг тодорхойлохтой холбогдсон харилцааг зохицуулна.

1.2.Тусгай зөвшөөрөлтэй үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллага нь (цаашид “зуучлалын байгууллага” гэх) зөвхөн үл хөдлөх эд хөрөнгийн салбарт үйл ажиллагаа эрхэлнэ.

Хоёр. Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын үйл ажиллагаа эрхлэхэд тавигдах нөхцөл, шаардлага

2.1.Зуучлалын байгууллагын үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдийн хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээ нь 15,000,000.00 (арван таван сая) төгрөг байх бөгөөд дараах нөхцөл, шаардлагыг хангасан байна:

2.1.1.Компанийн тухай хуульд заасны дагуу үүсгэн байгуулагдсан, улсын бүртгэлийн байгууллагад бүртгүүлсэн байх;

2.1.2.хувь нийлүүлсэн хөрөнгийг мөнгөн хөрөнгөөр бүрдүүлэх бөгөөд зээлийн эх үүсвэрээр бүрдүүлээгүй, хууль ёсны орлого байх;

2.1.3.үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын салбарт 2-оос доошгүй жил ажилласан туршлагатай, агентуудыг мэргэшил, арга зүйгээр хангаж ажиллах, 1-ээс доошгүй брокертой байх;

2.1.4.үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын үйлчилгээг үзүүлэх чиг үүрэгтэй 1-ээс доошгүй агенттай байх;

2.1.5.брокер, агент нь Хорооноос баталсан сургалтын хөтөлбөрийн дагуу зохион байгуулагдсан сургалтад хамрагдаж, шалгалтад тэнцэж, гэрчилгээ авсан байх;

2.1.6.Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих ажилтан томилсон байх;

2.1.7.Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд заасан дотоод хяналтын болон эрсдэлийн удирдлагын хөтөлбөртэй байх;

2.1.8.үйл ажиллагаа эрхлэх ажлын байр, техник, тоног төхөөрөмж, программ хангамжтай байх;

2.1.9.байгууллагын үйл ажиллагааг зохицуулсан хөдөлмөрийн дотоод журам, ажилтнуудын ёс зүйн дүрэмтэй байх;

2.1.10.үйл ажиллагаа эрхлэх байгууллага нь 3 жилийн бизнес төлөвлөгөөг боловсруулан баталсан байх;

2.1.11.Хорооноос шаардсан бусад баримт бичиг;

2.1.12.энэ журмын нэгдүгээр хавсралт дахь маягтын дагуу өргөдөл гаргаж, дөрөвдүгээр хавсралтад заасан баримт бичгийг үнэн зөв, бүрэн гүйцэд Хороонд ирүүлэх.

2.2.Гадаадын хөрөнгө оруулалттай үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллага нь Хөрөнгө оруулалтын тухай хууль, энэ журмын 2.1-д заасан шаардлагаас гадна дараах шаардлагыг хангана:

2.2.1.хөрөнгө оруулах этгээдийн мөнгөн хөрөнгийн гарал үүсэл, үйл ажиллагааны талаар тухайн улсын холбогдох төрийн байгууллага эсхүл хууль хяналтын байгууллага, банк санхүүгийн байгууллагаас мэдээлэл, тодорхойлолт, лавлагаа авсан байх;

2.2.2.хуулийн этгээдийн эцсийн өмчлөгчийн талаар мэдээлэл ирүүлэх.

Гурав. Тусгай зөвшөөрөл эзэмшигчид тавигдах нийтлэг нөхцөл, шаардлага

3.1. Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагууд нь дараах нөхцөл, шаардлагыг хангаж ажиллана.

3.1.1. Монгол Улсын Иргэний хууль, Зөвшөөрлийн тухай хууль, Компанийн тухай хууль, Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль болон бусад хууль тогтоомж, Хорооноос баталсан дүрэм, журам, зааврыг дагаж мөрдөх;

3.1.2. Хорооноос баталсан журмын дагуу жил бүр болон тухай бүр төвлөрүүлэх зохицуулалт үйлчилгээний хөлсийг Хорооны холбогдох дансанд бүрэн гүйцэд төвлөрүүлэх;

3.1.3. холбогдох хууль тогтоомжийн дагуу Хорооны зайны болон газар дээрх хяналт, шалгалтад хамрагдах;

3.1.4. Хорооноос тогтоосон хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг хангаж ажиллах;

3.1.5. Хорооноос өгсөн үүрэг, даалгаврыг биелүүлэх;

3.1.6. Хорооноос тогтоосон тохиромжтой этгээдийн шалгуурыг хангаж ажиллах;

3.1.7. зуучлалын байгууллагын оноосон нэрийн өөрчлөлт нь үйлчлүүлэгчдийг төөрөгдүүлэхгүй, сөргөөр нөлөөлөхгүй байх;

3.2. Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын салбар, төлөөлөгчийн газар нь дараах нөхцөл, шаардлагыг хангаж ажиллана:

3.2.1. үйл ажиллагаагаа эрхлэх нутаг дэвсгэрийн хязгаарлалтыг тодорхойлсон, хаяг байршил нь тодорхой, байнгын ажлын байр, тоног төхөөрөмжтэй байх;

3.2.2. салбар, төлөөлөгчийн газрын удирдлага нь Хорооноос тогтоосон тохиромжтой этгээдийн шалгуурыг хангасан байх;

3.3.3. салбар, төлөөлөгчийн газрын дотоод хяналт болон бусад үйл ажиллагааг зохицуулах журамтай байх;

3.3. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь зөвшөөрлийн нөхцөл, шаардлагыг хангаж буй эсэх шийдвэрийг Хороо гаргана.

3.4. Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллага нь дараах өөрчлөлтүүдийн талаарх мэдээллийг тухай бүр Хороонд урьдчилан мэдэгдэнэ:

3.4.1. хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, хувьцаа эзэмшигчдийн бүтэц, бүрэлдэхүүний өөрчлөлт;

3.4.2. салбар, төлөөлөгчийн газар байгуулах;

3.4.3. оноосон нэрийн өөрчлөлт;

3.4.4. эрх бүхий албан тушаалтны өөрчлөлт;

3.4.5. Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих ажилтны өөрчлөлт;

3.4.6. үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын болон түүний салбар, төлөөлөгчийн газрын хаягийн өөрчлөлт;

3.4.7. Брокерын өөрчлөлт;

3.4.8. Агентын өөрчлөлт.

3.5. Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллага нь хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, хувьцаа эзэмшигчдийн бүтэц, бүрэлдэхүүнд дараах хэлбэрээр өөрчлөлт оруулж болно:

3.5.1. хувьцаа эзэмшигчдийн мөнгөн хөрөнгөөр;

3.5.2. үндсэн үйл ажиллагааны хуримтлагдсан ашгаас хуваарилсан ногдол ашгаар нэмж хөрөнгө оруулах;

3.5.3. хувьцаа нэмж гаргах;

3.5.4. хувьцаа эзэмшигчээс оруулсан хувьцааг Иргэний хуульд заасны дагуу өвлүүлэх, бэлэглэх, өөр хоорондоо болон гуравдагч этгээдэд худалдах;

3.5.5. Хорооноос тогтоосон хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг хангах боломжтой, санхүү, төлбөрийн чадварт сөргөөр нөлөөлөхгүй, хохирол учруулахгүй бол хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг хорогдуулах.

3.5. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь энэ журмын 3.4-т заасан өөрчлөлтүүдийг мэдэгдэхдээ хавсралтад дурдсан холбогдох баримт бичгүүдийг Хороонд ирүүлнэ.

3.6. Энэ журмын 3.4-т заасан өөрчлөлтүүдийг Хороонд мэдэгдсэний дараа Улсын бүртгэлийн байгууллагад бүртгүүлнэ.

3.7.Хуулийн этгээд нь Улсын бүртгэлийн байгууллагад бүртгүүлсэн буюу өөрчлөлт оруулсан улсын бүртгэлийн гэрчилгээ болон дүрмийн хуулбарыг Хороонд ирүүлнэ.

3.8.Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын албан ёсны хаяг болон салбар төлөөлөгчийн газрын хаягийн өөрчлөлтийг ажлын 10 өдрийн дотор Хороонд мэдэгдэнэ.

Дөрөв. Хяналт, хариуцлага

4.1.Хороо энэ журмын биелэлтэд хяналт тавьж, зөрчсөн этгээдэд холбогдох хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

--- о О о ---

“Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын үйл ажиллагааны журам”-ын нэгдүгээр хавсралт

**ҮЛ ХӨДЛӨХ ЭД ХӨРӨНГӨ ЗУУЧЛАЛЫН БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА
ЭРХЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ХҮССЭН ӨРГӨДӨЛ**

Өргөдөл гаргасан огноо	Он		Сар		Өдөр	
Өргөдөл гаргагч хуулийн этгээдийн оноосон нэр	Монгол					
	Англи (Хуулийн этгээдийн нэрийг латин үсгээр галиглан бичнэ)					
Улсын бүртгэлийн дугаар						
Регистрийн дугаар						
Хэсэг 1. Тусгай зөвшөөрөлтэй эрхлэх үйлчилгээний төрлөө сонгоно уу.						
Үл хөдлөх эд хөрөнгө, түүнтэй холбоотой эрхийг худалдах, худалдан авах, шилжүүлэх үйл ажиллагааг зуучлах үйлчилгээ						
Үл хөдлөх эд хөрөнгө, түүнтэй холбоотой эрхийг түрээслүүлэх, түрээслэх, хөлслөх, хөлслүүлэх үйл ажиллагааг зуучлах үйлчилгээ						
Үл хөдлөх эд хөрөнгийг худалдан авч засварлан борлуулах үйлчилгээ						
Үл хөдлөх хөрөнгийн менежментийн үйлчилгээ						
Хэсэг 2. Тусгай зөвшөөрлийн хүрээнд үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдийн мэдээлэл						
Өмнө нь үл хөдлөхийн салбарт үйл ажиллагаа эрхэлж байсан эсэх					тийм	үгүй
Үүсгэн байгуулагдсан огноо	Он		Сар		Өдөр	
Хуулийн этгээдийн хэлбэр	Хувьцаат компани					
	Хязгаарлагдмал хариуцлагатай компани					
Хөрөнгө оруулалтын хэлбэр	Дотоодын хөрөнгө оруулалттай					
	Гадаадын хөрөнгө оруулалттай					
Хаяг байршил	Аймаг/хот					
	Сум/дүүрэг					
	Баг/хороо					
	Гудамж, байр					
	Тоот					
	Холбоо барих утас					
Цахим хуудасны мэдээлэл						
Цахим хаяг						
Харилцах	Банкны нэр					
	Дансны дугаар					
	Валютын төрөл					
	Үлдэгдэл		₮			
Хадгаламж	Банкны нэр					
	Дансны дугаар					
	Валютын төрөл					
	Үлдэгдэл		₮			
Хувь нийлүүлсэн хөрөнгийн талаарх мэдээлэл:						

Хувьцаа эзэмшигчдийн овог, нэр/оноосон нэр	Хувьцааны тоо (ширхэг)	Хувьцааны төрөл		Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ (₮)		ХНХ- д эзлэх хувь (%)
		ДЭХ	ЭХ			
Хэсэг 3.Хувьцаа эзэмшигчдийн талаарх мэдээлэл						
Үүсгэн байгуулагч этгээдийг сонгоно уу.					Иргэн	
					Хуулийн этгээд	
Хувьцаа эзэмшигч нь хуулийн этгээд бол дараах мэдээллийг бөглөнө үү.						
Хуулийн этгээдийн оноосон нэр	Монгол					
	Англи (Хуулийн этгээдийн нэрийг латин үсгээр галиглан бичнэ)					
Улсын бүртгэлийн дугаар						
Регистрийн дугаар						
Үүсгэн байгуулагдсан огноо	Он		Сар		Өдөр	
Хуулийн этгээдийн хэлбэр	Хувьцаат компани					
	Хязгаарлагдмал хариуцлагатай компани					
Хөрөнгө оруулалтын хэлбэр	Дотоодын хөрөнгө оруулалттай					
	Гадаадын хөрөнгө оруулалттай					
Бизнесийн болон үйл ажиллагааны чиглэл						
Хуулийн этгээдийн эцсийн өмчлөгчийн мэдээлэл	Овог, нэр					
	Регистрийн дугаар					
Оруулсан хувь нийлүүлсэн хөрөнгө	₮					
Хаяг байршил	Аймаг/хот					
	Сум/дүүрэг					
	Баг/хороо					
	Гудамж, байр					
	Тоот					
Холбоо барих утас						
Цахим хуудасны мэдээлэл						
Цахим хаяг						
Компанийн тухай хуулийн 6.14-д заасан компанийн нэгдлийн оролцогч эсэх?					Тийм	Үгүй
Тийм бол доорх мэдээллийг нэгдлийн оролцогч бүрээр бөглөнө үү.						
Оноосон нэр						
Регистрийн дугаар						
Хуулийн этгээдийн хэлбэр	Хувьцаат компани					

	Хязгаарлагдмал хариуцлагатай компани					
Тусгай зөвшөөрөл хүсэгч хуулийн этгээдтэй ямар холбоотой болох (толгой, хараат, охин, зэргэлдээ... гэх мэт)						
Үүсгэн байгуулагдсан огноо	Он		Сар		Өдөр	
Үйл ажиллагааны төрөл						
Хаяг байршил	Аймаг/хот					
	Сум/дүүрэг					
	Баг/хороо					
	Гудамж, байр					
	Тоот					
	Холбоо барих утас					
Холбоо барих утасны дугаар						
Цахим хуудасны мэдээлэл						
Цахим хаяг						
Хувьцаа эзэмшигч нь иргэн бол дараах мэдээллийг бөглөнө үү.						
Овог, нэр						
Регистрийн дугаар						
Оршин суугаа хаяг						
Эрхэлж буй ажил албан тушаал						
Ажлын байрны хаяг						
Эзэмшсэн мэргэжил						
Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ						₮
Харилцах дансны үлдэгдэл						
Хадгаламжийн дансны үлдэгдэл						
Хэсэг 4. Удирдлага болон боловсон хүчний талаарх мэдээлэл						
ТУЗ-тэй эсэх	Тийм		Үгүй		Бүрэлдэхүүний тоо	
Хяналтын зөвлөлтэй байх эсэх	Тийм		Үгүй			
Дотоод хяналтын нэгжтэй эсэх	Тийм		Үгүй			
Нийт ажилтны тоо						
Албан тушаал	Овог, нэр	Харьяалал	Регистрийн дугаар	Утасны дугаар	Эзэмшсэн мэргэжил	Дипломын дугаар
ТУЗ-ийн дарга						
ТУЗ-ийн гишүүн						
Хяналтын зөвлөл болон дотоод хяналтын нэгжийн дарга						
Хяналтын зөвлөл болон дотоод хяналтын нэгжийн гишүүн						
Гүйцэтгэх захирал						
Нягтлан бодогч						

Брокер					
Агент					
Бусад					

Тэмдэглэл: (Дээрх мэдээллийг албан тушаалтан бүрээр бичнэ үү.)

Хэсэг 5. Үйл ажиллагаа эрхлэх ажлын байрны мэдээлэл

Худалдаж авсан	
Түрээсэлсэн	
Бусад	

Тэмдэглэл: үйл ажиллагаа эрхлэх ажлын байрны хаяг байриил нь хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээн дэх хаяг байриил, дүрэмд тусгагдсан хаяг байриилтай ижил байхыг анхаарна уу!

Хэсэг 6. Ашиглах техник, тоног төхөөрөмж, програм хангамжийн мэдээлэл

Техник, тоног төхөөрөмжийн нэр төрөл	Техникийн үзүүлэлт	Худалдан авсан	Түрээслэсэн	Тоо ширхэг	Үнэ ₮
Программ хангамжийн нэр төрөл	Програмын зориулалт	Худалдан авсан	Түрээслэсэн	Тоо ширхэг	Үнэ ₮

Хэсэг 7. Тусгай зөвшөөрөлтэйгөөр эрхлэх үйл ажиллагааны төлөвлөлт

Үзүүлэлтүүд	Он	Он	Он
Харилцагч үйлчлүүлэгчдийн тоо			
Эх үүсвэрийн өртөг ₮			
Нийт орлого ₮			
Нийт зарлага ₮			
Хүлээгдэж буй ашиг ₮			
Өөрийн хөрөнгийн өгөөж ₮			
Активын өгөөж ₮			

Зөвшөөрлийн тухай хууль, энэ журам болон холбогдох бусад хууль тогтоомжийн дагуу тусгай зөвшөөрөл авахад шаардагдах баримт бичгийг үнэн зөв бүрдүүлж, хүргүүлэв. Бүрдүүлсэн баримт бичигт ямар нэг худал ташаа зүйл орсон байвал хариуцлагыг бид хүлээх болно.

Манай өргөдөл, баримт бичгийг хүлээн авч, хянан шийдвэрлэж, үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгоно уу.

Тусгай зөвшөөрөл авснаас хойш Зөвшөөрлийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомж, Санхүүгийн зохицуулах хорооноос өгсөн үүрэг даалгаврыг биелүүлж ажиллах болно.

Өргөдөл гаргасан:

Эрх бүхий албан тушаалтан

гарын үсэг

огноо

“Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын
үйл ажиллагааны журам”-ын хоёрдугаар хавсралт

**ҮЛ ХӨДЛӨХ ЭД ХӨРӨНГӨ ЗУУЧЛАЛЫН
БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААТАЙ ХОЛБООТОЙ ХОЛБОГДОХ
ӨӨРЧЛӨЛТИЙГ МЭДЭГДЭХ ӨРГӨДӨЛ**

Өргөдөл гаргасан огноо	Он		Сар		Өдөр	
Өргөдөл гаргагч зуучлалын байгууллагын оноосон нэр	Монгол					
	Англи (Хуулийн этгээдийн нэрийг латин үсгээр галиглан бичнэ)					
Улсын бүртгэлийн дугаар						
Регистрийн дугаар						
Өөрчлөлтийн төрлийг сонгоно уу.						
	Салбар, төлөөлөгчийн газар нээх					
	Оноосон нэрээ өөрчлөх					
	Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, хувьцаа эзэмшигчдийн бүтэц, бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах.					
Хэсэг 1. Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, хувьцаа эзэмшигчдийн бүтэц, бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах						
	Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээнд өөрчлөлт оруулах					
	Хувьцаа эзэмшигчдийн бүтэц, бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах					
А.Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээнд өөрчлөлт оруулах						
Оноосон нэр/Овог нэр	Регистрийн дугаар	Одоогийн ХНХ хэмжээ (₮)	Нэмэгдсэн (₮)	Хорогдсон (₮)	Өөрчлөлт орсны дараах ХНХ хэмжээ (₮)	ХНХ-д эзлэх хувь (%)
<i>Тэмдэглэл: (Дээрх мэдээллийг хувьцаа эзэмшигч бүрээр бичнэ.)</i>						
Б.Хувьцаа эзэмшигчдийн бүтэц, бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах						
Этгээд	Оноосон нэр	Овог, нэр	Харьяалал	Регистрийн дугаар	Хувьцааны тоо (ш)	ХНХ-ийн хэмжээ (₮)
Хэсэг 2.Салбар, төлөөлөгчийн газар нээх						
Салбар, төлөөлөгчийн байгуулах шийдвэрийн дугаар					Огноо	
Салбар, төлөөлөгчийн газрын үйл ажиллагааны чиглэл						
	Аймаг/хот					

Хаяг байршил	Сум/дүүрэг						
	Баг/хороо						
	Гудамж, байр						
	Тоот						
	Холбоо барих утас						
Салбар, төлөөлөгчийн газрын удирдах албан тушаалтны мэдээлэл							
Овог	Нэр	Харьяалал	Регистрийн дугаар	Утасны дугаар	Эзэмшсэн мэргэжил	Дипломны дугаар	
Салбар, төлөөлөгчийн газрын брокер, агентын мэдээлэл							
Албан тушаал	Овог	Нэр	Харьяалал	Регистрийн дугаар	Утасны дугаар	Эзэмшсэн мэргэжил	
Брокер							
Агент							
Салбар, төлөөлөгчийн газрын үйл ажиллагааны төлөвлөлт							
Үзүүлэлтүүд					Он	Он	
Харилцагч үйлчлүүлэгчдийн тоо							
Эх үүсвэрийн өртөг ₮							
Нийт орлого ₮							
Нийт зарлага ₮							
Хүлээгдэж буй ашиг ₮							
Өөрийн хөрөнгийн өгөөж ₮							
Активын өгөөж ₮							
Салбар төлөөлөгчийн газрын үйл ажиллагаа эрхлэх ажлын байрны мэдээлэл							
Худалдаж авсан							
Түрээслэсэн							
Бусад							
Ашиглах техник төхөөрөмж, программ хангамжийн талаарх мэдээлэл							
Техник, тоног төхөөрөмжийн нэр төрөл		Техникийн үзүүлэлт		Худалдан авсан	Түрээслэсэн	Тоо ширхэг	Үнэ ₮
Программ хангамжийн нэр төрөл		Үзүүлэлт	Худалдан авсан	Түрээслэсэн	Тоо ширхэг	Үнэ ₮	
Хэсэг 3. Оноосон нэр өөрчлөх							

Хуучин нэр		Регистрийн дугаар	
Шинэчилсэн нэр			
Оноосон нэрийг өөрчлөх болсон шалтгаан			

Холбогдох хууль тогтоомж болон энэ журамд нийцүүлэн холбогдох өөрчлөлтийг мэдэгдэхэд шаардагдах баримт бичгийг үнэн зөв бүрдүүлж, хүргүүлэв. Бүрдүүлсэн баримт бичигт ямар нэг худал ташаа зүйл орсон байвал хариуцлагыг бид хүлээх болно.

Манай өргөдөл, баримт бичгийг хүлээн авч, хянан шийдвэрлэж, зөвшөөрлийг олгоно уу.

Өргөдөл гаргасан:

Эрх бүхий албан тушаалтан

гарын үсэг

огноо

“Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын үйл ажиллагааны журам”-ын гуравдугаар хавсралт

**ҮЛ ХӨДЛӨХ ЭД ХӨРӨНГӨ ЗУУЧЛАЛЫН БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ
АЖИЛЛАГААТАЙ ХОЛБООТОЙ ӨӨРЧЛӨЛТИЙГ
МЭДЭГДЭХ ӨРГӨДӨЛ**

Өргөдөл гаргасан огноо	Он		Сар		Өдөр	
Өргөдөл гаргагч зуучлалын байгууллагын оноосон нэр	Монгол					
	Англи (Хуулийн этгээдийн нэрийг латин үсгээр галиглан бичнэ)					
Улсын бүртгэлийн дугаар						
Регистрийн дугаар						
Өөрчлөлтийн төрлийг сонгоно уу.						
	Эрх бүхий албан тушаалтны өөрчлөлт					
	Мөнгө угаах терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих ажилан, агентын өөрчлөлт					
	Брокерын өөрчлөлт					
	Агентын өөрчлөлт					
	Хаяг байршлын өөрчлөлт					
Хэсэг 1. Эрх бүхий албан тушаалтны өөрчлөлт						
Албан тушаал	Овог	Нэр	Харьяалал	Регистрийн дугаар	Утасны дугаар	
Хэсэг 2. Мөнгө угаах терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих ажилан, брокер, агентын өөрчлөлт						
Албан тушаал	Овог	Нэр	Харьяалал	Регистрийн дугаар	Утасны дугаар	
Хэсэг 3. Хаяг байршлын өөрчлөлт						
Өөрчлөлт оруулсан хаяг	Өөрчлөлт орж буй нэгжийн нэр					
	Аймаг/ хот					

байршлийн мэдээлэл	Сум/дүүрэг	
	Баг/хороо	
	Гудамж, байр	
	Тоот	
	Холбоо барих утас	

Энэ журам болон холбогдох бусад хууль тогтоомжид нийцүүлэн бүртгүүлэхэд шаардагдах баримт бичгийг үнэн зөв бүрдүүлж, хүргүүлэв. Бүрдүүлсэн баримт бичигт ямар нэг худал ташаа зүйл орсон байвал хариуцлагыг бид хүлээх болно.

Манай өргөдөл, баримт бичгийг хүлээн авч, хянан шийдвэрлэж, бүртгэж өгнө үү.

Өргөдөл гаргасан:

Эрх бүхий албан тушаалтан

гарын үсэг

огноо

“Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын үйл ажиллагааны журам”-ын дөрөвдүгээр хавсралт

ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ХҮСЭЛТ ГАРГАХАД БҮРДҮҮЛЭХ БАРИМТ БИЧГИЙН ЖАГСААЛТ

№	Баримт бичгийн төрөл	Хуудасны тоо
1	Энэхүү журмын 1 дүгээр хавсралтаар баталсан маягтын дагуу тусгай зөвшөөрөл хүссэн өргөдөл	
2	Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын үйл ажиллагаа эрхлэх тухай төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол хувьцаа эзэмшигчдийн хурал/-ийн шийдвэрийн эх хувь эсхүл нотариатаар баталгаажуулсан хуулбар	
3	<p>Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүсэгч хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээний нотариатаар баталгаажуулсан хуулбар, гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжийн хувьд Гадаадын хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан төрийн байгууллагаас олгосон гэрчилгээний нотариатаар баталгаажуулсан хуулбараас гадна дараах бичиг баримтыг ирүүлнэ. Үүнд:</p> <p>1.Харьяалах улс, оронд зээл, батлан даалтын гэрээгээр хүлээсэн хугацаа хэтэрсэн аливаа өргүй болохыг нотлох баримт бичиг;</p> <p>2.Харьяалах улс, оронд гааль, татварын өртэй эсэхийг харуулсан баримт бичиг;</p> <p>3.Харьяалах улс, оронд ял шийтгэлгүй болохыг нотлох баримт бичиг;</p>	
4	<p>Улсын бүртгэлд бүртгүүлсэн компанийн дүрэм болон шинэчилсэн дүрмийн төсөл. Тус дүрмийн төсөлд Компанийн тухай хуулийн 16 дугаар зүйлд зааснаас гадна дараах зүйлийг тусгасан байна. Үүнд:</p> <p>1.хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, бүтцэд өөрчлөлт оруулах нөхцөл;</p> <p>2.хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдах журам, их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэл хийхэд баримтлах журам, энэ талаарх удирдлагын бүрэн эрх;</p> <p>3.хувьцаа эзэмшигчдийн хурал, төлөөлөн удирдах зөвлөл болон Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих ажилтны эрх, үүрэг, хариуцлага;</p> <p>4.хувьцаа арилжих, бусдад шилжүүлэх, харилцан хязгаарлалт хийх үйл ажиллагааны зохицуулалт;</p> <p>5.татан буугдах үндэслэл, удирдлага, брокер, агентын буруутай үйл ажиллагаанаас хөрөнгө оруулагч, харилцагчдад учруулсан хохирлыг барагдуулах арга хэлбэр, хариуцлага хүлээх зарчим.</p>	
5	Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдийн хувь нийлүүлсэн хөрөнгийн эх үүсвэр нь хууль ёсны орлогоос бүрдсэн болохыг нотлох бичиг баримт, гарал үүслийн талаарх тодорхойлолт	
6	Хувьцаа эзэмшигч нь хуулийн этгээд бол эцсийн өмчлөгчийн талаарх мэдээлэл	
7	Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдийн хувь нийлүүлсэн хөрөнгөд ногдох мөнгөн хөрөнгийг өөрийн харилцагч банкны дансанд байршуулсан талаарх банкны тодорхойлолт, бусад баталгаа	
8	Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 14.1-т заасан дотоод хяналтын болон эрсдэлийн удирдлагын хөтөлбөр болон түүнийг баталсан шийдвэр.	
9	Сүүлийн жилийн санхүүгийн тайлан, шинээр үүсгэн байгуулж байгаа бол эхлэлтийн баланс	
10	Эрх бүхий албан тушаалтнууд болон мөнгө угаах терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих ажилтан нарын энэ журмын 12 дугаар хавсралтын дагуу гаргасан тодорхойлолт	

10	Брокер, агентуудын энэ журмын 2.1.5-д заасан гэрчилгээний хуулбар, энэ журмын 12 дугаар хавсралтын дагуу гаргасан тодорхойлолт	
11	Ажлын байр нь компанийн өөрийн байр бол үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээ, түрээсийн байр бол түрээсийн гэрээний нотариатаар баталгаажуулсан хуулбар	
12	Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын үйл ажиллагааг зохицуулсан хөдөлмөрийн дотоод журам, ажилтнуудын ёс зүйн журам;	
13	Бизнесийн төлөвлөгөө	
14	Үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдийн дотоод зохион байгуулалтын бүтэц, танилцуулга	
15	Үндсэн үйл ажиллагаанд ашиглах техник тоног төхөөрөмжийн жагсаалт	

“Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын үйл ажиллагааны журам”-ын тавдугаар хавсралт

ҮЛ ХӨДЛӨХ ЭД ХӨРӨНГӨ ЗУУЧЛАЛЫН БАЙГУУЛЛАГЫН ХУВЬ НИЙЛҮҮЛСЭН ХӨРӨНГИЙН ХЭМЖЭЭ, ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН БҮТЭЦ, БҮРЭЛДЭХҮҮНД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХАД БҮРДҮҮЛЭХ БАРИМТ БИЧГҮҮД

№	Баримт бичгийн төрөл	Хуудасны тоо
1	Энэ журмын 2 дугаар хавсралт дахь маягтын дагуу хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, хувьцаа эзэмшигчдийн бүтэц, бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулахыг хүссэн өргөдөл	
2	Өөрчлөлт оруулахыг зөвшөөрсөн хувьцаа эзэмшигчдийн хурлын тэмдэглэл, шийдвэр, холбогдох гэрээ хэлцэл, нотлох баримт бичиг	
3	Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, хувьцаа эзэмшигчдийн бүтэц, бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулахтай холбогдуулан гаргасан шинэчилсэн дүрмийн төсөл	
4	Шинэ хувьцаа эзэмшигчийн хувь нийлүүлсэн хөрөнгөд оруулах мөнгөн хөрөнгийн гарал үүсэл нь хууль ёсны орлогоос бүрдсэн эсэхийг нотлох баримт бичиг	
5	Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдийн хувь нийлүүлсэн хөрөнгөд ногдох мөнгөн хөрөнгийг өөрийн харилцагч банкны дансанд байршуулсан талаарх банкны тодорхойлолт, бусад баталгаа	
6	Шинэ хувьцаа эзэмшигч нь Хорооноос тогтоосон тохиромжтой этгээдийг тодорхойлох шалгуурыг хангасан эсэхийг нотлох баримт бичиг. (тохиромжтой этгээдийг тодорхойлох асуулгад үнэн зөв, бүрэн гүйцэд хариулан ирүүлэх)	
7	Хувьцаа эзэмшигч нь хуулийн этгээд бол эцсийн өмчлөгчийн талаарх мэдээлэл	

“Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын үйл ажиллагааны журам”-ын зургаадугаар хавсралт

**ҮЛ ХӨДЛӨХ ЭД ХӨРӨНГӨ ЗУУЧЛАЛЫН БАЙГУУЛЛАГЫН САЛБАР,
ТӨЛӨӨЛӨГЧИЙН ГАЗАР БАЙГУУЛАХАД БҮРДҮҮЛЭХ БАРИМТ БИЧГҮҮД**

№	Баримт бичгийн төрөл	Хуудасны тоо
1	Энэ журмын 2 дугаар хавсралт дахь маягтын дагуу салбар, төлөөлөгчийн газар байгуулахыг хүссэн өргөдөл	
2	Салбар, төлөөлөгчийн газар байгуулах эрх бүхий этгээдийн шийдвэр	
3	Ажлын байр нь компанийн өөрийн байр бол үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээ, түрээсийн байр бол түрээсийн гэрээний нотариатаар баталгаажуулсан хуулбар	
4	Тухайн нутаг дэвсгэрт салбар байгуулан ажиллуулахтай холбогдсон зах зээлийн судалгаа	
5	Салбарын удирдлагаар ажиллах этгээд болон агентын энэ журмын 2.1.5-д заасан гэрчилгээний хуулбар, энэ журмын 12 дугаар хавсралтын дагуу гаргасан тодорхойлолт	
6	Нэмэлт өөрчлөлт оруулсан дүрмийн төсөл	
7	Салбарыг удирдлагаар ханган ажиллах этгээд нь Хорооноос тогтоосон тохиромжтой этгээдийг тодорхойлох шалгуурыг хангасан эсэхийг нотлох баримт бичиг	

“Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын үйл ажиллагааны журам”-ын долоодугаар хавсралт

ҮЛ ХӨДЛӨХ ЭД ХӨРӨНГӨ ЗУУЧЛАЛЫН БАЙГУУЛЛАГЫН ОНООСОН НЭРИЙН ӨӨРЧЛӨЛТИЙГ МЭДЭГДЭХЭД БҮРДҮҮЛЭХ БАРИМТ БИЧГҮҮД

№	Баримт бичгийн төрөл	Хуудасны тоо
1	Оноосон нэр өөрчлөх эрх бүхий этгээдийн шийдвэр	
2	Улсын бүртгэлийн байгууллагаас авсан хуулийн этгээдийн оноосон нэрийн баталгаажуулалтын хуудас	
3	Оноосон нэрийн өөрчлөлтийг оруулсан компанийн шинэчилсэн дүрмийн төслийн эх хувь	
4	Тусгай зөвшөөрлийн гэрчилгээ, гэрчилгээний хавсралтын эх хувь	

“Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын үйл ажиллагааны журам”-ын наймдугаар хавсралт

**ҮЛ ХӨДЛӨХ ЭД ХӨРӨНГӨ ЗУУЧЛАЛЫН БАЙГУУЛЛАГЫН ЭРХ БҮХИЙ АЛБАН
ТУШААЛТАН, МӨНГӨ УГААХ, ТЕРРОРИЗМЫГ САНХҮҮЖҮҮЛЭХТЭЙ
ТЭМЦЭХ ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХЯНАЛТ ТАВИХ АЖИЛТНЫ
ӨӨРЧЛӨЛТИЙГ МЭДЭГДЭХЭД БАРИМТ БИЧГҮҮД**

№	Баримт бичгийн төрөл	Хуудасны тоо
1	Энэ журмын 3 дугаар хавсралтын дагуу гаргасан өргөдөл	
2	Шинээр томилогдож буй эрх бүхий албан тушаалтан болон Мөнгө угаах терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих ажилтан нь Хорооноос тогтоосон тохиромжтой этгээдийн шалгуурыг хангасан эсэхийг нотлох баримт бичиг (Тохиромжтой этгээдийг тодорхойлох асуулгад үнэн зөв, бүрэн гүйцэд хариулан ирүүлэх)	
3	Томилсон тухай шийдвэр, тушаал	
4	Энэ журмын 12 дугаар хавсралтын дагуу гаргасан тодорхойлолт	
5	Шинээр томилогдож буй брокерын энэ журмын 2.1.5-д заасан эрх олгох сургалтын гэрчилгээний хуулбар.	
6	Эрх бүхий албан тушаалтантай байгуулсан хөдөлмөрийн гэрээний нотариатаар гэрчлүүлсэн хуулбар	

“Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын үйл
ажиллагааны журам”-ын есдүгээр хавсралт

**ҮЛ ХӨДЛӨХ ЭД ХӨРӨНГӨ ЗУУЧЛАЛЫН БАЙГУУЛЛАГЫН БРОКЕРЫН
ӨӨРЧЛӨЛТИЙГ МЭДЭГДЭХЭД БАРИМТ БИЧГҮҮД**

№	Баримт бичгийн төрөл	Хуудасны тоо
1	Энэ журмын 3 дугаар хавсралтын дагуу гаргасан өргөдөл	
2	Шинээр томилогдож брокер нь Хорооноос тогтоосон тохиромжтой этгээдийн шалгуурыг хангасан эсэхийг нотлох баримт бичиг (Тохиромжтой этгээдийг тодорхойлох асуулгад үнэн зөв, бүрэн гүйцэд хариулан ирүүлэх)	
3	Томилсон тухай шийдвэр, тушаал	
4	Энэ журмын 12 дугаар хавсралтын дагуу гаргасан тодорхойлолт	
5	Шинээр томилогдож буй брокерын энэ журмын 2.1.5-д заасан эрх олгох сургалтын гэрчилгээний хуулбар.	
6	Эрх бүхий албан тушаалтантай байгуулсан хөдөлмөрийн гэрээний нотариатаар гэрчлүүлсэн хуулбар	
7	Үл хөдлөх хөрөнгийн салбарт 2-оос доошгүй жил ажилласан туршлагыг нотлох баримт бичиг	

“Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын үйл
ажиллагааны журам”-ын аравдугаар хавсралт

**ҮЛ ХӨДЛӨХ ЭД ХӨРӨНГӨ ЗУУЧЛАЛЫН БАЙГУУЛЛАГЫН АГЕНТЫН
ӨӨРЧЛӨЛТИЙГ
МЭДЭГДЭХЭД БҮРДҮҮЛЭХ БАРИМТ БИЧГҮҮД**

№	Баримт бичгийн төрөл	Хуудасны тоо
1	Энэ журмын 3 дугаар хавсралтын дагуу гаргасан өргөдөл	
2	Томилсон шийдвэр, тушаал	
3	Шинээр томилогдож агентын энэ журмын 2.1.5-д заасан эрх олгох гэрчилгээний хуулбар	
4	Энэ журмын 12 дугаар хавсралтын дагуу гаргасан тодорхойлолт	

“Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалынбайгууллагын үйл ажиллагааны журам”-ын арван нэгдүгээр хавсралт

ҮЛ ХӨДЛӨХ ЭД ХӨРӨНГӨ ЗУУЧЛАЛЫН БАЙГУУЛЛАГЫН ХАЯГ, БАЙРШЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙГ МЭДЭГДЭХЭД БҮРДҮҮЛЭХ БАРИМТ БИЧГҮҮД

№	Баримт бичгийн төрөл	Хуудасны тоо
1	Энэ журмын 3 дугаар хавсралт дахь маягтын дагуу гаргасан хаяг байршлын өөрчлөлтийг бүртгүүлэхийг хүссэн өргөдөл	
2	Хаяг байршлыг өөрчлөх тухай эрх бүхий албан тушаалтны шийдвэр	
3	Ажлын байр нь компанийн өөрийн байр бол үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээ, түрээсийн байр бол түрээсийн гэрээний нотариатаар гэрчлүүлсэн хуулбар	

“Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын үйл ажиллагааны журам”-ын арван хоёрдугаар хавсралт

ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТАН БОЛОН БУСАД БОЛОВСОН ХҮЧНИЙ ТОДОРХОЙЛОЛТ

Компанийн тухай хуулийн 84.1-д заасан эрх бүхий албан тушаалтан, хувьцаа эзэмшигч, эцсийн өмчлөгч, Мөнгө угаах терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих ажилтан, брокер, агентын талаарх мэдээлэл

1.Ерөнхий мэдээлэл

2.Боловсрол /Ерөнхий боловсролын сургуулийг оролцуулан бичнэ/

№	Төгссөн сургууль	Эзэмшсэн мэргэжил	Элссэн он	Төгссөн он	Диплом, гэрчилгээний дугаар

3.Ажлын туршлага

№	Хаана ажиллаж байсан	Албан тушаал	Ажилд орсон он, сар, өдөр	Ажлаас гарсан он, сар, өдөр	Шалтгаан

4.ТУЗ-ийн дарга, гишүүн, гүйцэтгэх удирдлага, хувьцаа эзэмшигч, эцсийн өмчлөгч, Мөнгө угаах терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих ажилтан, брокер, агентын холбогдох этгээдийн байдал:

Компанийн тухай хуулийн 89.2-т заасан нэгдмэл сонирхолтой этгээдийн мэдээлэл

№	Таны хэн болох	Овог, нэр (Хуулийн этгээдийн нэр)	Регистрийн дугаар	Эрхлэж буй ажил, албан тушаал

ТОДОРХОЙЛОЛТ ГАРГАСАН:

/...../

/...../

/...../

/Овог, нэр/

/гарын үсэг/

огноо